

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 8 ДУГААР САРД  
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ**

2022.08.30

Сайншанд

/2022.08.02/ Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан тус ангийн баярын хурал боллоо. Баярын хуралд аймгийн ИТХ-ын дарга Б.Ганзориг оролцож, нийт бие бүрэлдэхүүнд түүхт ойн баярын мэнд хүргэж, эрхэлсэн ажилдаа идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажиллаж буй зарим албан хаагчдад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшууллаа.

/2022.08.16/ Бүгд найрамдах Турк улсын Сакарья хотын дарга ноён Екрем Юже, гэргийн хамт Дорноговь аймгийн ИТХ-ын дарга Б.Ганзоригийн урилгаар Дорноговь аймагт айлчилж, Хоёр орны найрамдалт хамтын ажиллагааны илэрхийлэл болох Дорноговь аймаг Сакарья хоттой ах дүүсийн харилцаа тогтоох хамтын ажиллагааны **санамж бичиг** байгууллаа.

Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд

1. Мэдээлэл туршлага солилцох
2. Эдийн засгийн хамтын ажиллагаа
3. Боловсрол, эрүүл мэнд, залуучууд спорт, аялал жуулчлал, түүх соёлын өвийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, эрчим хүч, соёл урлаг, техник технологи, тээвэр харилцааны салбаруудад хэрэгжинэ.

Хоёр орны найрамдалт харилцааны илэрхийлэл болсон ах дүүсийн харилцаа тогтоож буй энэхүү айлчлалын хүрээнд Турк улсын Сакарья хотын даргад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Б.Ганзориг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ногоон байгууламж байгуулах чиглэлээр мод үржүүлгийн мэргэжилтэн сургах, чадварлаг боловсон хүчин бэлтгэх, нарийн мэргэжлийн ажилтнуудыг чадавхжуулах солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, залуучуудын хөгжлийг дэмжсэн спортыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах саналыг дэвшүүлсэн.

/2022.08.31/ "Хүүхэд хөгжил-2022" зорилтот жилийн хүрээнд Зүүнбаян багийн иргэн Оюунбаатарын гэр бүлийн зүгээс хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, тэдний хүмүүжилд эерэгээр нөлөөлөх үлгэр дуурайлал болсон тоглоомын талбайн бүтээн байгуулалтыг өөрсдийн хөрөнгөөр барьж байгуулан орон нутагтаа хүлээлгэн өгсөнд иргэн хүний ухамсар, сэтгэл, өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан энэхүү үйлсэд талархал илэрхийлэн аймгийн ИТХ-ын дарга Б.Ганзориг, аймгийн ИТХ-ын төлөөлөгч Л.Наранбаатар, Ц.Болормаа нар талархлын БАТЛАМЖ хадгалуулсан.

### **Аймгийн ИТХ-ын даргын шагнал**

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр 4, “Өргөмжлөл”-өөр 15 нийт 19 иргэнийг шагнаж урамшуулсан байна.

### **Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн тогтоол**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс нийт 4 тогтоол баталсан.

### **Аймгийн ИТХ-ын даргын захирамж**

Аймгийн ИТХ-ын даргын нийт 7 захирамж гарснаас ангилбал Буцалтгүй тусламж олгох тухай-1, Зардал гаргах тухай-2, Шагнах тухай-3, Дэмжлэг үзүүлэх тухай-1 болно.

### **Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал**

08 дугаар сард аймгийн ИТХ-ын нарийн бичгийн Ажилд томилох тухай 3 тушаал гарсан.

### **ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:**

### **НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС**

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн “ERP” системийн заавар зөвлөмжийг 6 байгууллагын 21 албан хаагчдад цахимаар болон танхимаар өгч ажилласан.

Төрийн үйлчилгээний операторын 5 ажилтанд хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх чиглэлээр цахимаар 8 зааварчилгаа өгч ажилласан.

Аймгийн хэмжээнд тоон гарын үсгийн нэгдсэн судалгаа мэдээллийг гаргасан. Нийт 16-с дээш насны 3313 иргэн, 121 Аж Ахуйн нэгж тоон гарын үсэг ашиглаж байна.

Төрийн лавлах үйлчилгээний Call center үйлчилгээг нэвтрүүлэх 6 сумын схем зураглалыг гаргасан.

Байгууллагын дотоод сүлжээний бүтэц, зохион байгуулалтын чиглэлээр байгууллагын бүх өрөөний switch болон хэрэглэгчдийн тоог гарган ажилласан. Төрийн сангийн лангийн утсыг солиогүй байгаа, Байгууллагын дотоод сүлжээний схем зураглалыг гаргаж ажилласан.

Үүрэн телефоны Мобиком ХХК-тай хамтран ажилах гэрээний төслийг боловсруулан гэрээ байгуулах шатанд явж байна.

## **1.1 ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР**

### **Гамшгаас хамгаалах улсын хяналтын чиглэлээр:**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Сайншанд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 21 барилга байгууламжийг хамруулан Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын орлогч даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт зохион байгуулахад дараах нийтлэг зөрчил дутагдал илэрсэн. **Үүнд:**

Ажилчдын байрлах кемпийн гэр хоорондын зайг 5 м-ээс багагүй байхаар төлөвлөх шаардлагатай.

Пийшин зуухны галын аюулгүй байдлыг хангаж зуухны аман дээр 50x70 харьцаатай төмөр хамгаалалт хийх, яндангийн залгалтыг дээрээс доош угласан байдлаар хийх.

Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03-ын 6.2 дугаар бүлэгийн дагуу цахилгааны холболтыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх / *гэмтэлгүй цахилгаан дамжуулах утас ашиглах, цахилгаан дамжуулах утас газар дээгүүр хамгаалалтгүй татахгүй байх* /.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дах заалт, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн норм MNS 5566:2020 стандартын дагуу гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуураар бүрэн хангаж, кемп тус бүрт галын цэг байгуулах шаардлагатай.

Ил задгай орчинд ил гал гаргахгүй байх, тамхи татах тусгай цэг гаргаж тэмдэг тэмдэглээ байршуулах.

Кемп тус бүр цугларах цэг байгуулж тэмдэг тэмдэглээ байршуулах чиглэлээр хугацаатай үүрэг өгч, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан.

Цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас гэр нь нурж дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасан /Хатанбулаг сумын-7, Айраг сумын-3, Хөвсгөл сумын-2/ иргэнд холбогдох материалыг шалгаж Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн дүгнэлт гарган аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Сайншанд сумын 12 дугаар цэцэрлэг, Хөвсгөл суманд үйл ажиллагаа явуулдаг “Сора интернэшнл” ХХК-ны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж баталгаажуулсан.

#### **Гамшгийн нөхцөл байдлын талаар:**

Сайхандулаан сум /1-р баг/ /аймгийн төвөөс баруун зүгт 77км, сумын төвөөс зүүн урд зүгт 23км “Хүрээтийн Сухайт” гэдэг газар нутагладаг малчин Н.Лхагваа /26 настай эр/ 2022 оны 08 дугаар 28-ний өдрийн 16:00 цагийн орчимд гэрээсээ сураггүй байгаа мэдээллийг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 23:24 хүлээн авсан.

Сайхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Т.Ганбаатараар ахлуулсан 18 иргэн, 6 мотоцикль, 1 автомашинтай 2022.08.30-ны өдрийн 23:37 цагт ойр орчмын 10км радиуст эрэн хайх ажиллагааг зохион байгуулж 2022.08.31-ны 06:30 минутанд бороо орсны улмаас үерийн усанд урсаж нас барсан байдалтай олдсон.

#### **ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Төрийн үйлчилгээний хүсэлт бүртгэлийн хяналтын системд ирүүлсэн галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлтийг шалгаж үзээд Галын аюулгүй байдлын

тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-т “Холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлэх”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/154 дугаар тушаалаар баталсан Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журмын 2.1, 2.4 дэх заалтуудыг зөрчиж ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан үед үйл ажиллагаа явуулсан Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Өргөн зэрэг 6 сумын эрүүл мэндийн төвийн дарга нарт Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл хүргүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/515 дугаар захирамжийн хүрээнд Монгол улсын цахим хөгжил, харилцаа холбооны яамны захиалгаар Сайхандулаан Хөвсгөл, Хатанбулаг суманд ХУР системийн хүрээнд баригдсан харилцаа холбооны цамхаг барих ажлыг ашиглалтад хүлээн авах улсын комисст холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй хамтран орж барилга байгууламжийг хүлээн авах санал дүгнэлтийг гарган ажиллалаа.

### **ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:**

Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны Гангийн эрсдэлийн үнэлгээ хийх тухай 13/1684 дүгээр албан бичгээр ирүүлсэн аргачлал, загвар хүснэгтийн дагуу аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Мал эмнэлгийн газар, Хүнс, аж ахуйн газартай хамтран аймгийн хэмжээний гангийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээг хийхдээ Монгол улсын Шадар сайдын 2021 оны Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зааврыг шинэчлэн батлах тухай 68 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх зааврыг мөрдлөг болгож, бодит нөхцөл байдалд тулгуурлан, магадлал, үр дагаврын түвшнийг 1-3 оноогоор оноожуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайлан боловсруулж ирүүлэх, улмаар гамшгийн эрсдэлийн үнэлгээн дээр тулгуурлан гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох талаарх үүрэг чиглэлийг Сайхандулаан,

Мандах, Хатанбулаг сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг нийт 6 байгууллагад цахимаар хүргүүлсэн.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар хийсэн гангийн эрсдэлийн үнэлгээгээр тус аймаг нь Их эрсдэлтэй аймгуудад эрэмбэлэгдсэн тул Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газраас сум тус бүрээр нарийвчилж, ерөнхий үнэлгээ хийх үүрэг ирүүлсэн.

Эрсдэлийн үнэлгээ хийхэд баримтлах аргачлал, загвар хүснэгтийг сумдын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тухайн сум бүрийн бодит нөхцөл байдлын мэдээллийг гаргуулан нэгтгэхэд магадлалын түвшний ангиллаар - их түвшинд 34 оноотойгоор Айраг, Мандах, Хатанбулаг сум, дунд түвшинд бусад сумд хамаарч байна. Харин үр дагаврын түвшингийн ангиллаар бага түвшинд Айраг, Даланжаргалан, Замын-Үүд сумд, дунд түвшинд бусад сумд хамаарч байна.

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний нийт 4 тайлан хүлээгдэж байгаа ба Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний төв ТББ-аас тус газарт анхан шатны шинжилгээ хийлгэхээр 2021 онд ирүүлсэн Иххэт сумын нутаг дахь Хамар-Ус хайлуур жоншны уурхай, Даланжаргалан сумын нутаг дахь Сэрүүн цагааны хайлуур жоншны ордын ил уурхайн гамшгийн эрсдэлийн үнэлгээний 2 тайланг шатанд шилжүүлж ажилласан.

**Гал түймрийн дуудлагаар ажилласан байдал:** Тайлант хугацаанд Дорноговь аймгийн хэмжээнд гал түймрийн зөрчлийн дуудлага-2, гал түймрийн дуудлага-2, Эрэн хайх ажиллагааны мэдээлэл-1, мал амьтны гоц халдварт мялзан өвчний хязгаарлалтын дэглэм-1

Гал түймрийн 2 дуудлагаар нийт 14 алба хаагч, үндсэн албаны 1 автомашинтай үүрэг гүйцэтгэж нийт 12 минут ажиллан, 1,2 тонн гал унтраах бодис, 12,7 литр шатахуун зарцуулав.

**Эрэн хайх, аврах ажиллагааны мэдээлэл:**

Дорноговь аймгийн Сайхандулаан сум /1-р баг/ Улаан шороот багийн /аймгийн төвөөс баруун зүгт 77км, сумын төвөөс зүүн урд зүгт 23км, гэрээсээ зүүн урд зүгт 2 кмт “Хүрээтийн Сухайт” гэдэг газар нутагладаг малчин Н.Лхагваа /26 настай эр/

2022.08.28-ы өдрийн 16:00 цагийн орчимд гэрээсээ гараад одоог хүртэл сураггүй байгаа мэдээллийг 2022.08.30-ны өдрийн 23:24 хүлээн авсан.

Тус аймгийн Сайхандулаан сумын засаг даргын тамгын газрын дарга Т.Ганбатаар ахлуулсан 18 иргэн, 6 мотоцикль, 1 автомашинтай 2022.08.30-ний өдрийн 23:37 цагт ойр орчмын 10км радиуст эрэн хайх ажиллагааг зохион байгуулж 2022.08.31-ний 06:30 минутанд бороо орсны улмаас үерийн усанд урсаж нас барсан байдалтай олдсон.

**Мэдээ, мэдээлэл хүргэсэн байдал:** Цахим орчинд цаг агаарын 5 хоногийн мэдээ болон сэрэмжлүүлэх мэдээг тухай бүрт ард иргэдэд хүргэж ажиллаж байна.

## **1.2 ДОРНОГОВЬ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР**

### **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЛААР:**

МХЕГ-ын даргын 2022.06.28-ны 01/91 дугаартай “Боловсролын, сургалтын байгууллагуудын хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд урьчилан сэргийлэх шалгалт хийх” удирдамжаар Политехник колллеж, АШУҮИС, МСҮТ, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдын сургууль, цэцэрлэгүүд, Сайншанд сумын 2 сургууль, 10 цэцэрлэг, нийт 7 сургууль, 13 цэцэрлэгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. 3 сургууль, 2 цэцэрлэгт улсын байцаагчийн зөвлөмж, 1 цэцэрлэгт улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлсэн.

Аймгийн засаг даргын 2022.08.31-ний А/566 дугаар тушаал “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого зохион байгуулах тухай” захирамжаар батлагдсан ажлын хэсгийн хуралд оролцсон.

Мөн Сайншанд, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдын нийт 24 сургалтын байгууллагад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт хийж, ундны усны 21 дээж авч ажилласан.

Шалгалтын явцад улсын байцаагчийн дүгнэлт-7, хамтарсан зөвлөмж-1, албан шаардлага-1 тус тус бичиж хүргүүлсэн.

Сайншанд сумын Засаг даргын тамгын дарга баталсан 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Архи, тамхи тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагууд болон нийтийн эзэмшлийн зам талбайд худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд хяналт шалгалт хийх ажлын удирдамжийг үндэслэн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2022 оны 11/01 дугаартай удирдамжийн дагуу Сайншанд сумын 1,2,5 дугаар багуудын 17 объектийг хамруулж хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтын явцад 5 объектоос 51 нэр төрлийн 326 ширхэг 772900 төгрөгний хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүний зөрчил илэрч 11-03-010/42, 11-03-010/43, 11-03-010/44, 11-03-010/45, 11-03-010/46 дугаартай улсын байцаагчийн актуудыг үйлдэж Сайншанд сумын дэргэдэх захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг улсын

орлого болгох устгах орон тооны бус зөвлөлд шилжүүлж Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу 4 объектийг Хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 1 аж ахуй нэгж зөрчлийн хэрэг нээгдсэн .

Боловсролын сургалтын байгууллагуудын 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил шалгах улсын байцаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх цахим сургалтанд хамрагдсан.

МХГ-ын даргын баталсан 2022 оны 11/35 дугаартай төлөвлөгөөт бус удирдамжийн дагуу Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдын ЗДТГ-т шалгалт хийсэн. Үүнд:

Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийг хууль тогтоомжийн хүрээнд хийгдэж буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, арга зүйгээр хангаж ажилласан.

Аймгийн хэмжээнд хийгдэж буй “Мал угаалга, орчны халдваргүйтгэлийн аяны явцыг газар дээр шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Улаанбадрах суманд хийгдэж буй мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын гүйцэтгэлийг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Хатанбулаг, Улаанбадрах сумдад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар улсын байцаагчийн 7 заалт бүхий 2 албан шаардлагыг хүргүүлж ажилласан.

МХГ даргын 2022 онд баталсан 11/01 дугаартай удирдамжийн хүрээнд Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвүүдэд төлөвлөгөөт бус шалгалт хийж гүйцэтгэсэн.

Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах 3.32.1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төв 45,4% буюу “дунд” эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 56,6% Хөвсгөл сумын эрүүл мэндийн төв 24,8%. буюу “бага” эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 77.7% Улаанбадрах сумын эрүүл мэндийн төв 46,7% буюу “дунд” эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 62,2%.

Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийг шалгах №3.32.2 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төв 36.2% буюу “дунд” эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 63%, Хөвсгөл сумын эрүүл мэндийн төв 45.1% буюу “дунд” эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 52,9% Улаанбадрах сумын эрүүл мэндийн төв 37.3% буюу “дунд” эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 62,3% үнэлэгдсэн.

Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төвд 31 заалт, Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвд 20 заалт, Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төвд 25 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлсэн.



Дээрх Эрүүл мэндийн төвүүдэд “Эрүүл мэндийн байгууллагуудад нийтлэг илэрч байгаа дутагдал, шалтгаан, нөхцөл, арилгах арга зам”, “Эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулахад анхаарах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж 30 эмнэлгийн ажилтанг хамрууллаа.

Замын-Үүд сумын мэргэжлийн хяналтын тасаг нь 2022.08.27-09.02-ны өдрүүдэд Аймгийн засаг даргын А/44 дүгээр захирамжаар батлагдсан “Замын-Үүд боомтоор нэвтрэх ачаа тээврийг зохицуулах” түр журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Замын-Үүд суман дахь Гаалийн газрын Хилийн хорио цээрийн албанаас хийсэн 40тн- ийн 402, 20 тн- ийн 122 чингэлэг нийт 524 чингэлэгийн халдваргүйжүүлэлтэд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан

Иргэн У.Шинэбаярын гаргасан хүсэлтийн дагуу, 11/25 дугаарт удирдамжийн хүрээнд “Ноёд кебаб” түргэн хоолны газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэн “Дунд” эрсдэлтэй үнэлэгдсэн учир улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.

“Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ, “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж” “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт” зэрэг зөвлөмжүүдийг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ЗДТГ пэйж хуудсанд байршуулсан.

Аймгийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу нээлттэй нийгэм форумын захиалгаар “Өмгөөллийн ивээл баг” хуулийн нөхөрлөл нь “Газрын хэвлийн баялаг ашиглалтын талаар Засгийн газрын болон орон нутгийн байгууллагын чиг үүргийн хуваарилалт” сэдвээр судалгааны ажил гүйцэтгэж байгаатай холбогдуулан судалгааны ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой судалгааг гарган хүргүүлсэн.

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу МХЕГ-ын даргын баталсан 01/36 тоот “Улаанбаатар хот болон аймгуудын төвлөрсөн ба төвлөрсөн бус усанд цацрагийн хяналт шинжилгээ хийх” удирдамжийн хүрээнд “Чандмань- Илч” ОНӨХХК-ийн гүний худаг №1, гүний худаг №2, гүний худаг №3, гүний худаг №4, гүний худаг 1000 сангийн уснаас нийт 5 дээж авч Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Цацрагийн хяналтын лабораторид хийгддэг байгалийн болон зохиомол цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийг тодорхойлох шинжилгээнд хамруулсан.

Сорилтын лаборатори нь 29 аж ахуйн нэгжийн 245 сорьцонд 382 үзүүлэлт тодорхойлсон.

**ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН 8 ДУГААР САРД ХИЙЖ  
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 08 дугаар сард хэвлэгдэн гарсан “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2 дугаарыг хүлээн авч, нийтлэгдсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг төрөл тус бүрээр нь нэг бүрчлэн бүртгэж лавлагаа мэдээллийн санд баяжуулалт хийж ажиллалаа.

Засгийн газрын 1111 төвөөс ирүүлсэн 6 өргөдлийг хүлээн авч судлан холбогдох ажиллагаа явуулж цаг хугацаанд нь хариуг хүргүүлсэн.

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс Хөвсгөл сумын Засаг даргаар ажиллаж байсан Н.Энхбаяртай холбоотой асуудлаар ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох хариу тайлбарыг гарган хүргүүлсэн.

Улаанбадрах, Өргөн сумын Засаг дарга нараас 2022 оны 02 дугаар улиралд батлан гаргасан захирамжлалын баримт бичгүүдийг хянан үзэж холбогдох зөвлөгөө мэдээллийг өгсөн.

Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн барилгын өргөтгөлийн асуудал болон газар эзэмшүүлэх дуудлага худалдаанд оролцож зориудаар үнийн хөөрөгдөл бий болгож удаа дараа ялагч болсон хэрнээ газар эзэмших гэрээ байгуулахгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн асуудлыг шалган тогтоолгохоор аймгийн Цагдаагийн газарт албан бичгээр гомдол гаргасан.

Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан хөдөлгөөний эрчим нэмэгдэж байгаа энэ үеэр өмчлөх эрхийн эсрэг болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой санамж сэрэмжлүүлэг, постер мэдээллийг бэлтгэн цахим орчноор дамжуулан хүргэсэн.

2022.08.29-ний өдөр зохион байгуулагдсан сумдын Засаг дарга нарын уулзалтад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр үүрэг даалгавар өгсөн.

### **2.1 Архивын тасаг:**

Иргэдээс архивын лавлагаа авахыг хүссэн 65 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, 65 өргөдлийг шийдвэрлэсэн байна. Нийт 36 иргэнд архивын лавлагаа олгосон бөгөөд архивын лавлагааг ангилан үзвэл: Малын А данс 10 иргэнд, цалингийн тодорхойлолт 10, Иргэний гэр бүлийн лавлагаа-1, архивын тодорхойлолт 15 байна. Архивын мэдээллийн цахим сан болон цаасан суурьтай баримт шүүн үзэж 32 иргэнд архивын баримтын хуулбар 74-ийг олгосон. Нийт олгосон баримтын хуулбарын 57 цахим сангаас, 17 цаасан суурьтай баримт шүүж олгосон. Архивын ерөнхий газрын цахим лавлагааны системд 3 лавлагаа шийдвэрлэсэн.

Архивын тасгийн 2022 оны цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу Даланжаргалан сумын ЕБС-ийн 1984-2005 оны 12 хадгаламжийн нэгж, Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2014-2015 оны 14 хн, Карьерын аж ахуйн даргын тушаал 1986 оны 1 хадгаламжийн нэгжийн нийт 27 хадгаламжийн нэгжийн 3197 хуудас баримтыг EDOC программд шивж, 1494 заалт, 3698 хүний нэр тодорхойлон бичиж мэдээллийн сан үүсгэв.

Аймгийн архивын тасгийн 2022 оны нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу Тохижилт-Сайншанд хот тохижилтын газрын 2013-2016 оны 21 байнга хадгалах хадгаламжийн нэгж, Дэлгэрэх сумын Эрүүл мэндийн төвийн 2012-2015 оны 34 байнга хадгалах хадгаламжийн нэгж, Замын-Үүд сумын ИТХ-ын 2014-2017 оны 40 байнга хадгалах хадгаламжийн нэгж, Замын-Үүд сумын ЗДТГ-ын 1994-2016 оны 513 байнга хадгалах хадгаламжийн нэгж, Улаанбадарах сумын ЗДТГ-ын 2011-2016 оны байнга

хадгалах хадгаламжийн нэгж, Хилийн мэргэжилийн хяналтын албаны 2014-2017 оны 44 байнга хадгалах хадгаламжийн нэгжийг хүлээн авч сан хөмрөгөө баяжуулсан.

EDOC программын Хөмрөгийн нэр, нэрийн өөрчлөлт, Байгууллагын нэр, нэрийн өөрчлөлт, Зохион байгуулалтын нэгжийн нэр, нэрийн өөрчлөлтийг засаж шивж оруулж дууссан. Байгууллагын 5 компьютерийн хоосон /temp/ файлыг устгаж гацааг арилгаж check дискийг уншуулж системийн гэмтлийг зассан. Архивын тасгийн даргын компьютерийг форматлаж windows 10 64 bit үйлдлийн систем суулгаж office-2013, photoshop cs-6, тоон гарын үсгийн програм, avira вирусын програм, DocSignerInstaller програм зэрэг шаардлагатай программуудыг суулгаж хэвийн ажиллагааг хангасан.

## **2.2 Улсын бүртгэлийн хэлтэс:**

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр- 1022  
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр- 88  
Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр- 531  
Нийт 1641 бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлсэн.

## **2.3 Цагдаагийн газар:**

### **Нэг. Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц**

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах тухай” А/38 дугаар тушаалаар батлагдсан биелэлт үр дүн тооцох баримт бичгийн жагсаалтын дагуу тус цагдаагийн газраас улирал, хагас, бүтэн жилээр биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтыг гарган баталж алба хаагчдад танилцуулан эхний хагас жилд тайлагнах 76 биелэлтийг холбогдох алба, нэгж, газар, хэлтсүүдэд хүргүүлэн тайлагнасан.

### **Хоёр. Цаг үеийн болон урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээлэл**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 8 дугаар сард тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5, зам тээврийн осол 13, нийт 18 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж /зорчигч-1/, 5 хүн хүнд болон хүндэвтэр гэмтэл авсаныг /жолооч-2, зорчигч-3/ өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1 нэгжээр буюу 20.0 хувиар өссөн, нас барсан хүн түвшинд, гэмтсэн хүн 2 нэгжээр буюу 40.0 хувиар өссөн байна.

Гудамж замын хяналт шалгалтаар 2007 зөрчил илрүүлж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 89, эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 58 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан нийт 1860 жолоочийг 57.316.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 78 жолоочийн жолоодох эрхийг 1 жилийн хугацаатай хасаж, нийт 31.200.000 төгрөг, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 58 иргэнийг 11.600.000 төгрөгөөр торгож, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ жолоодох эрхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 26 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулсан.

Замын цагдаагийн тасаг, хэсгээс олон улсын чанартай автозамд замын хяналтын байнгын 3 цэгт 24 цагаар давхардсан тоогоор 11 алба хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Цагийн менежментийн постуудад 3 автомашинтай 6 алба хаагч хөдөлгөөнт эргүүл хийж хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажилласан. Гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хэсгийн төлөөлөгч, сумдын цагдаа нартай хамтран 2022.07.26, 29, 2022.08.27-ны өдрүүдэд нэгдсэн хяналт шалгалтыг хийж ажилласан.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Тавантолгой нүүрсний уурхайгаас Хатанбулаг сумын Ханги хилийн боомт хүртэл хагас сайжруулсан шороон замаар хөдөлгөөнд оролцож байгаа том оврын ачааны автомашины хөдөлгөөнд хяналт тавьж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Тавантолгой-Ханги хяналт шалгалт” арга хэмжээний удирдамж төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулж, Хатанбулаг сумын ЦТ, НХЖХТ, ЗЦТ-ийн алба хаагчид хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

“Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аяны хүрээнд аймгийн төвд Стадион орчмын зам дагуух самбарт аяны анносыг байрлуулсан. Мөн орон нутгийн автозамд Айраг сумын пост болон 35-р зөрлөгийн орчим Эрүүл мэндийн байгууллагатай хамтран хяналт шалгалтыг хийж, жолооч зорчигч нарын даралт биеийн байдлыг шалгаж эмч нар зөвлөгөө өгч эмнэлгийн үйлчилгээ үзүүлэн, жолооч нарын нойрыг сэргээн дасгал хөдөлгөөн хийлгэж, халуун кофе цай, ус ундаа, амин дэм, ваакуусаар үйлчилж, жолооч нарт зурагт пото стикер болон итгэлийн захиа зэргийн хамт хүргүүлж нэгдсэн өдөрлөгийн арга хэмжээг 2 удаа зохион байгуулж ажилласан.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс согтуурал шалгагч тандагч Alcotest-5000 маркийн 2 ш багажны 3.560.000 төгрөгийн санхүүжилтыг шийдвэрлүүлж, дээрх багажийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

“Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аяны хүрээнд шинэлэг санаа гаргаж босоо тэнхлэгийн А0102, А0103 зам дагуу аяны үгийг авто замын зорчих хэсэг дээр бичиглэл хийж ажилласан. Энэ хүү бичиглэлийг Сайншанд сум цагаан хаалга орчимд, түшлэг зам дагуу мөн Замын-Үүд сум, Айраг сумдууд зэрэг 10 цэгт хийж гүйцэтгэж ажилласан. Мөн Говьсүмбэр-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн А/0102, А/0103 тоот зам дээр зам тээврийн осол хэрэг ихээр гардаг цэгүүдэд нойр сэргээгч дэржигнүүрийг 8 цэгт “Дэлгэр баясах” ххк 30.000.000 сая төгрөгийн төсвөөр хийж ажилласан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авагдсан ажилтан, алба хаагчдаас энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй байх, алба хаагчиддаа Замын хөдөлгөөний дүрэм, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, дүнг ирүүлэх талаар Сайншанд өртөө, Хараацай

цэцэрлэг, Чандмань илч зэрэг ААНБ-д 86, 87, 88 дугаартай албан мэдэгдэл хүргүүлсэн.

Тус Цагдаагийн газраас 2022 оны 08 дугаар сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Аажуу авбал аяндаа хүрнэ дээ арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан ажилласан. Арга хэмжээний хүрээнд Босоо тэнхлэгийн А/0103 зам дагуу Сайншанд сумын Гурван замын болон бусад постууд мөн зам дээр үүрэг гүйцэтгэж ажиллаж байгаа алба хаагчид аяны хүрээнд дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийн жолооч нарт итгэлийн захиа түгээх, постер стикерийг тээврийн хэрэгслүүдэд наах, жолооч нараас аялахдаа аюулгүй байдлаа хангаж аажуу явах амлалт авч ядарсан чилсэн жолооч нарыг хэсэг хугацаанд амрааж биеийн чилээ гаргах дасгал хөдөлгөөн хийлгэж ус, ундаа зэрэг уух зүйлээр дайлж жолооч нарын биеийн чилээ ядаргааг багасгаж замын хөдөлгөөнд оруулж ажиллах үйл ажиллагааг өдөр бүр тогтмол томилгоот албан хаагчид хийж гүйцэтгэсэн.


Мөн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулдаг шатахуун түгээх Петровис, Сод Монгол, Шунхлай, Тэс петролиум зэрэг шатахуун түгээх станцууд түүнчлэн аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын Агар хурд, Датек, Хүрдшанд, Эргэл хурд, БХТН, Өсөх сайн жолоо зэрэг авто курсууд болон Дорноговь аймагт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажилласан.

Орон нутгийн замд явж буй чингэлэг тээвэр том оврын ачаа тээврийн болон хот хоорондын зорчигч тээврийн автобус нарын жолооч нартай мөн хамтран ажиллаж “Аажуу явал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээний постер зургийг тээврийн хэрэгслүүд дээр нь байршуулах нийтэд суртгачилах жолооч нарт аяны хүрээнд сурталчилгааг бусдад түгээх аянд нэгдэж холын замд явахдаа аюулгүй байдлаа хангах тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж замын хөдөлгөөнд оролцож байхыг сануулж алба хаагчид тогтмол хяналт шалгалт хийж ажилласан.

Дорноговь аймаг Сайншанд сумын төвийн автобусны буудал болон томоохон сурталчилгааны самбар мөн босоо тэнхлэгийн А/0103 зам дагуух самбарууд болон зарим хэсэгт шинээр самбар суурьлуулж “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аяны зурагт хэвлэл, Соёлтой жолооч зурагт хэвлэлийг самбаруудад байрлуулж ажиллалаа.

“Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аяны хүрээнд ард иргэдэд хурдан түгээх сурталчилах зорилгоор олны танил урлаг соёлын болон, спортын эрхэмүүдтэй хамтран ажиллаж олон нийтийн сүлжээ facebook, instagramm, twitter, зэрэг цахим хэлбэрээр зураг видео бичлэг зэргийг байршуулж ажилласан. Мөн түүнчлэн

Тээврийн цагдаагийн албанаас түгээж буй аяны бичлэг, контент, зурагт пост зэргийг “Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар” пейж хуудсанд байршуулж нийт алба хаагчдаар шейр түгээлт хийлгэх ажилд идэвхитэй хамруулсан.






“Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аяны хүрээнд шинэлэг санаа гаргаж босоо тэнхлэгийн А/0103 зам дагуу аяны үгийг авто замын зорчих хэсэг дээр бичиглэл хийж ажилласан. Энэхүү бичиглэлийг Сайншанд сум Цагаан хаалга орчимд, 33-р зөрлөг, Түшлэг зөрлөгийн зам дагуу мөн Замын-Үүд, Эрдэнэ, Айраг сумдууд зэрэг 10 цэгт хийж гүйцэтгэж ажилласан. Мөн Говьсүмбэр-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн А/0102, А/0103 дугаартай автозам дээр зам тээврийн осол хэрэг ихээр гардаг цэгүүдэд нойр сэргээгч дэржигнүүрийг 8 цэгт “Дорноговь АЗЗА”, “Дэлгэр баясах” ххк 30 сая төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн.

Замын-Үүд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс аяны хүрээнд зохион байгуулах, түүнд шаардагдах туслах материалын зардалд 1.989.000 төгрөгийг шийдүүлэн арга хэмжээнд ашиглаж ажилласан.


Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөр 5.520.000 төгрөг, Сайншанд сумын ГХУСАЗСЗ-өөс 500.000 төгрөгийн төсвийг шийдвэрлүүлэн, арга хэмжээнд хэрэглэх хулдаасан хэвлэл 12 ш, наадаг стикер 800 ш, жолооч нарт өгөх долины зүүлт 200 ш, жолоочид хүргэх зурвас 4000 ширхэг, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 8 төрлийн 6000 ш тараах материал зэргийг бэлтгэн хэвлүүлж жолооч нарт тараан ажиллав.

Мөн залилах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Залилагчид боломж бүү олго” арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулан ажиллаж байна.

“Дорноговь аймаг дахь цагдаагийн газар”-ын фейж хуудас “Дорноговь цагдаа”, “Замын-Үүд” цагдаа цахим хаягуудад “Залилах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 постер мэдээ, мэдээллийг бэлтгэн 2524 иргэний хандалтыг авч ажилласан. Дорноговь аймгийн Сайншанд сумын гэр бүлийн талбайд байрлах лед дэлгэц, Замын-Үүд сумын лед дэлгэцүүдээр Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн видео, шторк, контентуудыг түгээж ажилласан.



Тус Цагдаагийн газраас “Залилах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 10 төрлийн гарын авлагыг 10000 ширхэг бэлтгэн тус аймгийг дамжин өнгөрч байгаа жолооч, зорчигч болон Сайншанд сумын бүх нийтийн иргэдийн хуралд хүрэлцэн ирсэн иргэдэд тараан ажилласан.



самбараар шинэчлэн байрлуулсан.

Мөн 2022-2023 оны Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан “Хичээл эхэллээ-2022” арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй DTV телевизэд 1 удаагийн мэдээлэл өгч “Дорноговь цагдаа”, “Замын-Үүд цагдаа” фэйсбүүк хуудсанд мэдээллийг тухай бүрт түгээлт хийн ажилласан.

Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан нээлтийн арга хэмжээний үед аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгийн ойр орчимд нийтийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор 135 цагдаагийн алба хаагчийг

гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэмэлтээр үүрэг гүйцэтгүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

## **2.4 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар**

### **Цагдан хорих байрны талаар**

Хоригдогч, хоригдлын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэн ажиллаж үзлэг, нэгжлэгийг тогтмол хугацаанд чанартай зохион явуулан ажилласан.

Цагдан хорих байрны үйл ажиллагаа цагийн хуваарийн дагуу хэвийн явагдаж ямар нэг гэмт хэрэг, зөрчил дутагдалгүй байна.

### **Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр**

2021 оны эхний үлдэгдэл 233 гүйцэтгэх баримт бичгийн 3372662,4 төгрөгийн төлбөр дээр шинээр шүүхээс 1996773,3 төгрөгийн үнийн дүнтэй 306 гүйцэтгэх баримт бичиг, харьяаллын дагуу алба хооронд 50120,7 төгрөгийн үнийн дүнтэй 6 гүйцэтгэх баримт бичиг, түдгэлзүүлснийг сэргээсэн 140622,4 төгрөгийн үнийн дүнтэй 12 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор 375881,6 төгрөгийн үнийн дүнтэй 67 гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлж, газар хооронд 141337,2 төгрөгийн үнийн дүнтэй 12 гүйцэтгэх баримт бичиг шилжүүлж нийт гүйцэтгэвэл зохих 4551436,1 төгрөгийн үнийн дүнтэй 477 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 436251,1 төгрөгийн үнийн дүнтэй 178 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 246097,2 төгрөгийн үнийн дүнтэй 124 гүйцэтгэх баримт бичигт хэсэгчилсэн төлөлт хийж тайлант хугацааны эцэст 3866583,1 төгрөгийн үнийн дүнтэй 299 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй ажилласан.

Тайлант хугацааны эцэст гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж 37,7 хувьтай байна.

Хүүхдийн тэтгэлгийн 2021 оны эхний үлдэгдэл 309233,3 төгрөгийн үнийн дүнтэй 269 гүйцэтгэх баримт бичиг дээр шинээр 385744,3 төгрөгийн үнийн дүнтэй 33 гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч, 70,2 төгрөгийн үнийн дүнтэй 21 гүйцэтгэх баримт бичиг газар хооронд харьяаллаар шилжүүлж, гүйцэтгэвэл зохих 694907,4 төгрөгийн үнийн дүнтэй 300 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 51930,4 төгрөгийн үнийн дүнтэй 25 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 166 гүйцэтгэх баримт бичгийн 305137,1 төгрөгийг хэсэгчлэн биелүүлж, тайлант хугацааны эцэст 332309,9 төгрөгийн үнийн дүнтэй 275 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэлийн бодит биелэлтийн дундаж гүйцэтгэх баримт 8,3 хувь мөнгөн дүн 52,2 хувьтай байна.

### **ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС АЛБАН БИЧИГ ХЭРГИЙН ТАЛААР:**

Тус хэлтэст 08 дугаар сар нийт 94 бичиг ирсэн. Үүнээс:

- Хариутай 25 албан бичгийн хугацаанд нь хүргүүлсэн
- Хугацаа нь болоогүй байгаа 8
- Хэрэгжүүлж ажиллах бичиг 35
- Хүсэлт ирүүлсэн 26



Засаг даргын 17 захирамжийг төлөвлөн гаргаж, үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

### **1. Худалдан авах ажиллагааны талаар:**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 59, Замын сангаар 5, ОНХСангаар 4, Их засварын хөрөнгө оруулалтаар 8 ажил нийт 87 ажил батлагдсан. Үүнээс 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 82 төсөл арга хэмжээний тендерийг зарласанаас үйл ажиллагаа гүйцэтгэж дууссан 28, үйл ажиллагаа явагдаж байгаа 52, тендер нээх хугацаа болоогүй 3, тендер зарлагдаагүй 4 ажил байна. Нийт батлагдсан төсөл арга хэмжээний тендерийн зохион байгуулалт 95,4 %-тай явагдаж байна.

### **2. Санхүүжилтийн талаар:**

01-08 дугаар сарын мэдээгээр өссөн дүнгээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 9 ажлын гүйцэтгэлд 8,7 тэрбум төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтын 77 ажлын гүйцэтгэлд 13,4 тэрбум төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 5 ажлын гүйцэтгэлд 4,6 тэрбум төгрөг, Замын сангийн 3 ажлын гүйцэтгэлд 772,2 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

### **3. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл явцын талаар:**

Бүтээн байгуулалтын чиглэлээр 8, 9 дүгээр сард хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг Засаг даргын орлогчоор батлуулан ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэгийн барилга, засварын ажил гүйцэтгэж байгаа аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг хяналт шалгалтаар явж ажилласан. Гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдэд 08 дугаар сарын 20 гэхэд ажил гүйцэтгэж дуусгасан байх үүрэг чиглэл өгч, ГХБХГазраас өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын дууссан ажилд улсын комисс ажиллуулах хүсэлт ирсэний дагуу ГХБХГазартай хамтран ажлыг хүлээн авсан.

Автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх 3 ажил дуусч хүлээн авах ажлын хэсэг, захиалагч байгууллага, гүйцэтгэгч компаниудтай хамтран техникийн шалгуур үзүүлэлтийн дагуу хянан шлгаж хүлээн авсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цэвэр усны нөөц сангийн ажлыг гүйцэтгэж байгаа Энержипарагон ХХК-ний гүйцэтгэлийн тайланг Сангийн яамны [pimis.publicinvestment.gov.mn](http://pimis.publicinvestment.gov.mn) программд шивж, санхүүжилт хүссэн албан бичгийг хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын дууссан төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Засаг даргын Тамгын газрын сайтад олон нийтэд мэдээллэж ажилласан.

Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэрэгжүүлэх 9,10 дугаар сарын төлөвлөгөөг гаргаж Тамгын газрын даргад өгсөн.

## **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Тус байгууллагын харьяа албад нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ болон цаг үеийн шуурхай ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

## 1. Мал аж ахуйн салбарын чиглэлээр:

Мал аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 277-р тогтоол, Аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврыг сумдад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ онд 4665 малчин өрхийн 3.0 сая толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан төлөвтэй байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны жилийн эцсээр 1167266 толгой эх мал төллөхөөс 756124 эх мал төллөж нийт 758364 төл хүлээн авч төллөлт 87.3 хувь төл бойжилт 99.9 хувьтай эцэслэв.

Дорноговь аймгийн хэмжээнд 2022 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар бэлчээрийн ургац 0.0 – 4.8 ц/га байна. Аймгийн нийт нутгийн 20 хувь нь зуншлага сайн, 30 хувь нь зуншлага хэвийн, 50 хувь нь зуншлага муу байна.

Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн:  
**23.9 % - 50 хүртлэх хувь (бэлчээрийн нөөцтэй)**  
**15.6 % - 51-100 хувь (бэлчээр хүрэлцээтэй)**  
**34.4 % – 101-300 хувь (даац 1-3 дахин хэтэрсэн)**  
**7.7 % -301-500 хувь (даац 3-5 дахин хэтэрсэн)**  
**18.4 % – 500 хувиас их (даац олон дахин хэтэрсэн) байна.**

Өөрөөр хэлбэл өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 40 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 60 гаруй хувьд хэтэрч гарлаа.

2022-2023 онд аймгийн хэмжээнд хонин толгойд шилжүүлснээр нийт 434.6 толгой малыг хүнсэнд хэрэгцээлэх болон зах зээлд борлуулах урьдчилсан судалгаа гараад байна

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12-р сарын 04-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолоор Алтанширээ, Иххэт, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг сумдын 108,9 га бэлчээрийн газрыг сум дундын отрын нөөц нутгаар тусгай хэрэгцээнд 5 жилийн хугацаагаар авсан.

Аймаг дундын отрын бүс нутагт оторлох малчин өрхийн саналыг сумдаас авахад гадны аймагт оторлохгүй, цаг хүндэрсэн үед аймаг дотроо оторлох саналыг ирүүлсэн.

Цаг хүндэрсэн үед аймаг дотор оторлох ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Тус аймагт аймаг дундын отрын бүс нутаг байхгүй хилийн зурваст 6 сумын 148 өрхийн 125 мянган толгой мал, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 2 сумын 164

өрхийн 103.7 мянган толгой мал нийт 312 өрхийн 228.7 мянган толгой мал хилийн зурваст болон улсын тусгай хамгаалалттай бүс нутагт отроор өвөлжиж, хаваржих урьдчилсан төлөвлөгөөтэй байна.

Өөр аймгийн нутагт 7 сумын 53 өрхийн 29.4 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 6 сумын 253 өрхийн 103.8 мянган толгой мал, сум дундын отрын бүс нутагт 1 сумын 2 өрхийн 2.1 мянган толгой мал намаржиж байна.

Эрдэнэ суманд Өвөрхангай аймгийн 1 өрхийн 297 толгой мал намаржиж байна.

Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор тус Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, Сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл нийт аймгийн хэмжээнд 660 тн өвс, 500 тн тэжээл бэлтгэх даалгавартайгаас одоогийн байдлаар аймгийн аюулгүйн нөөцөд 250 тн өвс, 61.5 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 190 тн өвс байна.

Тус аймгийн нутагт хадлан хийх боломж байдаггүй боловч жил бүрийн өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангахад шаардагдах аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг хил залгаа аймгаас бэлтгэх ажил хийгддэг.

Аймгийн өвс тэжээлийн нөөц бэлтгэх ажлын хүрээнд ОНТ-ын **100** сая төгрөгийн хөрөнгөөр нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаад байна.Тендерийг 2022 оны 09 -р сарын 05 –ны өдөр нээнэ.

Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээлэл, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино, дунд хугацааны урьдчилсан мэдээ, өвөлжилтийн хувийн бэлтгэл эртнээс хангах талаар “Масс мессеж” –ээр давхардсан тоогоор нийт 20281 малчдад мэдээлэл хүргүүлсэн.

#### Бэлчээрийн усан хангамжийн талаар:

Аймгийн хэмжээнд бэлчээрт инженерийн хийцтэй-476, богино яндант-29, бетон хашлагат-534, энгийн уурхай -2163 нийт 3202 худаг ашиглагдаж байна.

Энэ онд Улсын төсвийн 157.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гарах 5 инженерийн хийцтэй худгийн гүйцэтгэгчээр Эхний эхэн ХХК шалгарч гэрээ байгуулаад байна.

Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Мандах, Улаанбадрах, Замын-Үүд сумдын СОНХС-ын 420.0 сая төгрөгийн хөрөнгөөр 21 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргах ажил хийгдэж байна.

2022 оны 08 сарын байдлаар инженерийн хийцтэй 9 худгийн шинээр болон сэргээн засварлаж 10.5 мянган га бэлчээрийг усжуулж 12.0 мянган толгой малыг усжуулах боломж бүрдсэн.

## **2. Газар тариалангийн салбарын чиглэлээр**

Аймгийн хэмжээнд 2022 оны хавар 14 сумын 219 иргэн, 23 аж ахуйн нэгж 33.90 га-д малын тэжээл, 24.54 га-д төмс, 62.37 га-д хүнсний ногоо, 15.20 га-д жимс жимсгэнэ нийт 136.01 га-д тариалалт хийсэн.

2022 оны ургац хураалтын урьдчилсан блансаар тус аймаг нь 73 тн малын тэжээл, 96 тн төмс, 410 тн хүнсний ногоо нийт 579 тн ургац хураан авах төлөвлөгөөтэй байна.

Аймгийн хэмжээнд 900 тн-ын зоорь хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Тус аймгийн хураан авах ургацын нийт хэмжээ 300-600 тн байдаг тул зоорийн хангамж 100% байна.

Газар тариалан эрхлэгчдэд МУ-ын Засгийн газраас 3 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай зээл олгохоор шийдвэрлэж 4 иргэн, 1 хоршоонд 69.6 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.

#### Мөнгөн урамшуулал олгох мөнгөн бус дэмжлэг үзүүлэх

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" 118 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Сангийн сайд, ХХААХҮС-ын хамтарсан "Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх" журам батлагдсан.

10 нэр төрлийн хүнсний ногооны 1 тонн тутамд 100 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгох шийдвэр гарсантай холбогдуулан хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд мөнгөн урамшуулал олгох бэлтгэл ажлыг хангах сургалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Татварын хэлтэстэй хамтран 2022 оны 08 дугаар сарын 17-нд Сайншанд суманд зохион байгуулж 13 сумын Газар тариалангийн мэргэжилтэн болон тариаланчдын төлөөлөл нийт 62 иргэн, ААН хамрагдсан.

Газар тариалангийн цахим систем (Plant.gov.mn)- д тус аймгаас 136 тариаланч бүртгүүлэхээс 08/31-ний байдлаар 97 иргэн, 10 хуулийн этгээд бүртгэгдэж бүртгэл 78.6%-тай явагдаж байна.

#### Бага оврын тракторын зээл:

Хөдөө аж ахуйг дэмжих сантай Бага оврын тракторын зээлийн үлдэгдлийн тулгалт хийхэд тус аймгийн 30 зээлдэгч 95.113.500 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. БОТ-ын төлбөр барагдуулалтыг 2022/09/01-ний дотор барагдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар сумдын Засаг дарга нарт албан бичгийг хүргүүлсэн.

### **3. Хүнс, худалдаа, нийтийн хоолны салбарын чиглэлээр**

БШУЯ, ХХААХҮЯ, Монголын Хүнсчдийн холбооны хамтран зохион байгуулсан Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн хоол, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж, шийдэл уулзалтад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны асуудал хариуцсан мэргэжилтэн болон 14 сумын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, Сургуулийн өмнөх боловсрол болон

Ерөнхий боловсролын сургуулийн холбогдох мэргэжилтэн, хүнс үйлдвэрлэгчийн нийт 53 төлөөлөл оролцсон.

Төв суурин газрын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан бэлтгэх 275.2 тн махны хэрэгцээний тооцоололыг гарган сумдад хүргүүлэн чиглэл өгч ажиллаж байна.

№	Сумын нэр	Нийт хүн амын тоо	Төв суурин газрын ЖДХА-н тоо	ЖДХА-н 1 хоногийн хэрэглээ гр	Нэг хоногийн хэрэгцээ, /тонн/			3 сарын хэрэгцээ /тонн/
					гр	кг	тн	
1	Айраг	3591	1770.63	120	212475.6	212.4756	0.2124756	19122.804
2	Алтанширээ	1357	225.28	120	27033.6	27.0336	0.0270336	2433.024
3	Даланжаргалан	2983	659.79	120	79174.8	79.1748	0.0791748	7125.732
4	Дэлгэрэх	1925	265.65	120	31878	31.878	0.031878	2869.02
5	Замын-Үүд	18999	7723	120	926760	926.76	0.92676	83408.4
6	Иххэт	2085	727.57	120	87308.4	87.3084	0.0873084	7857.756
7	Мандах	1561	236.46	120	28375.2	28.3752	0.0283752	2553.768
8	Өргөн	2131	864.91	120	103789.2	103.7892	0.1037892	9341.028
9	Сайншанд	27451	10653	120	1278360	1278.36	1.27836	115052.4
10	Сайхандулаан	1273	291.78	120	35013.6	35.0136	0.0350136	3151.224
11	Улаанбадрах	1523	254	120	30480	30.48	0.03048	2743.2
12	Хатанбулаг	3007	436.76	120	52411.2	52.4112	0.0524112	4717.008
13	Хөвсгөл	1535	303.66	120	36439.2	36.4392	0.0364392	3279.528
14	Эрдэнэ	2362	1071.7	120	128604	128.604	0.128604	11574.36
Нийт		71783	25484.19	120	3058102.8	3058.103	3.0581028	275229.252

#### 4. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны салбарын чиглэлээр

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, зах зээлийг тэлэх, борлуулалтыг дэмжих зорилгоор "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр-2022" арга хэмжээнд Далд мөнгөн шанд ХХК, Дорнын Үжин гоо ХХК амжилттай оролцож Дорнын Үжин гоо ХХК нь Шилдэг ААН-ээр шалгарсан.

Экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох зар мэдээллийг 2022 оны 6 сарын 06-наас АЗДТГ, ХХААГ, сумдын цахим хуудсаар мэдээллэн аймгийн [me.gov.mn](http://me.gov.mn) цахим хаягаар эцсийн байдлаар баталгаажуулж илгээсэн 13 төсөл, 1.470.987.780 төгрөгийн зээлийн хүсэлт хүлээн авсан.

Хүлээн авсан төслүүдийн материалын иж бүрдлийг журмын дагуу шалган төслийн урьдчилсан шинжилгээнд 8 төслийг шилжүүлж 2022 оны 08 сарын 15-наас 8 сарын 23 өдрүүдэд шинжилгээ хийж нарийвчилсан судалгаанд шилжүүлсэн.

Нарийвчилсан судалгааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газраас томилогдсон ажлын хэсэг 2022 оны 08 сарын 26-27-ны өдрүүдэд тус аймагт ажиллаж төсөл ирүүлсэн ААН-үүдийн үйл ажиллагаатай танилцаж үнэлгээ хийсэн.

## **ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС**

1. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг ханган, аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд Төрийн өмчийн 33, хувийн 3, төмөр замын 6, нийт 42 Хүүхдийн цэцэрлэгт 4500 гаруй хүүхэд, Ерөнхий боловсролын 22 сургуульд 15700 гаруй сурагч хамрагдаж, 1 дүгээр ангид 1700 гаруй сурагч элсэн орсон. Мөн аймгийн Политехникийн коллежид 630, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуульд 600 гаруй оюутан хамрагдаж, шинээр нийт 450 гаруй оюутан элсэн орсон.
2. Монгол улсын Соёлын яам, Нийслэлийн Соёл урлагийн газар, Соёлын өвийн Үндэсний төвөөс зохион байгуулсан "Нүүдэлчин Монгол-2022" дэлхийн соёлын фестиваль 2022 оны 08 сарын 12-14-ний өдрүүдэд Улаанбаатар хот, Горхи-Тэрэлжийн үзэсгэлэнт газар зохион байгуулагдсан. Тус наадамд Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газар, Музей сургалт судалгааны төв, "Саран хөхөө" театраас хамтран говь нутгийнхаа өв соёлыг дэлгэн үзүүлж, Шилдэг ахмад өвлөн уламжлагчаар Сайншанд сумаас оролцогч Н.Лантуу - Батламж, 500,000 төгрөгөөр, Уламжлалт баяр ёслол, зан үйл, тоглоом наадгай, уриа дуудлага ай савын шилдэг өвлөн уламжлагчаар Дэлгэрэх сумаас оролцогч С.Сэрээтэр "Малын уриа дуудлага" төрөлд хонь тойглох өвөөр шалгарч - Батламж, 1,000,000 төгрөгөөр, Шилдэг гар урлалын үзэсгэлэнгийн баг хамт олноор Дорноговь аймгийн гар урлалын үзэсгэлэн шалгарч - Батламж, 1,000,000 төгрөгөөр, нийт 636 оноогоор Дорноговь аймаг ГУТГААР байр эзэлж 50,000,000 төгрөгөөр шагнуулсан.
3. Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан түүх, үл хөдлөх дурсгалын улсын тооллогын талаарх цахим сургалтад хамрагдаж, аймгийн Засаг даргын 2022 оны А/566 дугаар захирамжаар тооллого зохион байгуулах ажлын хэсэг байгуулан бэлтгэл ажлыг хангаад байна.
4. Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын харьяат МУСТА нэрт морин хуурч Чойн Банзрагч, МУСГЗ яруу найрагч Самдангийн Долд нарын 1962 онд зохиосон "Алтан говийн унага" уртын дууны 60 жилийн ойд зориулсан уртын дуу дуулаачдын улсын анхдугаар наадмыг зохион байгуулж, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Хэнтий, Төв, Дорнод аймгууд, Улаанбаатар хотоос болон Дорноговь аймгийн сумдаас нийт 29 авьяаслаг уран бүтээлчид, уртын дуучид оролцсон.

### **Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ 2022 оны 08 сарын байдлаар**

<b>Үйлчилгээ</b>	<b>Тоо хэмжээ</b>
<b>Шинэ ажлын байрны</b>	194 буюу өмнөх оны мөн үеийнхээс 62-оор буурсан

<b>тоо:</b>	байна.
<b>Ажилд зуучлагдсан иргэдийн тоо:</b>	399 буюу өмнөх оны мөн үеийнхээс 10-аар өссөн.
<b>Ажлын байрны захиалгын тоо:</b>	518 буюу өмнөх оны мөн үеийнхээс 10-аар өссөн байна.
<b>Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо:</b>	236 буюу өмнөх оны мөн үеийнхээс 440-өөр буурсан.

## 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

### А. Зохион байгуулсан арга хэмжээ

#### Нэг. Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

1. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн Старт-Ап арга хэмжээнд оролцох хүсэлтэй иргэдийн бүртгэлийг 2022 оны 08 дугаар сарыг 08-ны өдрөөс 29-ний өдрийг дуустал 21 хоногийн хугацаанд зарлаж зар мэдээг ХХҮГазрын пэйж хуудас болон орон нутгийн DTV телевиз, түүний пэйж хуудсанд байршуулж, мэдээлэл хүргэж ажилласан. 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 9 иргэн бүртгүүлээд байна.



**StartUp**  
2022 ДОРНОГОВЬ АЙМАГ

Шулгэг стартап залуу болон залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох

#### УРАЛДААН

Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, саначгаа гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-Ап” залуу залуучуудын биед шалгаруулж 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоно.

Бүртгэлийн хувицаа:  
2022.08.08-2022.08.29-ний  
дуустал

Холбоо барих  
утас: 92080989



2. Жижиг зээл арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 09 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал хугацаанд зарлан зар мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх зорилгоор зурган постер хийж ХХҮГазрын пэйж хуудас болон орон нутгийн DTV телевиз болон мэдээллийн хэрэгслээр хүргэж ажилласан.

**ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

“Хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөр”-ийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэж байна.

**Зорилго:**  
Бичил бизнес эрхлэгч таны аж ахуй тогтвортой үйл ажиллагаа эрхлэх чадавхыг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, цаашид тогтвортой хадгалахыг дэмжих.

**Хамрах хүрээ:**  
- Ажилгүй иргэн  
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн  
- Нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжийн хэлбэрээр бичил бизнес эрхлэгч иргэн

**Арга хэмжээ:**  
1. Зээлийн өмнөх сургалт  
2. Жижиг зээл олгох  
3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ

**Зээлийн хэмжээ:** 5-10 сая хүртэл төгрөг

**Зээлийн хүү:** 7.2%

**Бүртгэл:** 2022 оны 08 дугаар сарын 24-с 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал

**Хаана:** Иргэдийн хөгжлийн нэгдсэн төв 307 тоот  
☎ - 92080989 дугаараас авна уу.

3. “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах арга хэмжээд хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан иргэн С.Цогцэцэгийн үйл ажиллагаатай танилцаж, хяналт тавьсан.



### **Хоёр. Нийтлэг үйлчилгээний хүрээнд:**

**1. Ажил хайгч:** Нийт 12 иргэнийг ажил хайгчаар шинээр бүртгэн, 5 иргэнийг /шилжсэн, ажилд орсон, өөрийн хүсэлтээр зэрэг шалтгаанаар/ бүртгэлээс хасан, ажилгүйдлийн тодорхойлолт 30 хүнд гаргаж ажилласан.

**2. Ажлын байрны захиалга, түүний зар мэдээ:** Тайлант сард 7 ААНБ-аас 19 ажлын байрны захиалга авч, ажлын байрны зарыг DTV телевиз, 89.1 FM, ХХҮГазрын вэйб хуудас, ажил хайгч иргэдийн нэгдсэн группд байршуулан, тохирох мэргэжлийн ажил хайгч иргэд рүү утсаар холбогдон санал тавьж сонирхсон иргэдийн анкетыг хүлээн авч ажилласан.

**3. Ажилд зуучлах үйлчилгээ:** : GIP ХХК-д ажлын байрны захиалгын дагуу 10 иргэнийг ажилд зуучлалаа.

**4. Хамтран ажиллах гэрээ:** “Идэр ширэгү” ХХК –тай “Хамтран ажиллах гэрээ” №36 гэрээ байгуулсан.


### **Гурав. Бусад үйл ажиллагааны хүрээнд:**

1. Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд зохион байгуулагдаж байгаа залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн 3-р ээлжийн бүртгэл эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын пэйж хуудас, орон нутгийн телевиз, Ажил хайгч иргэдийн нэгдсэн групп, Орон нутгийн зарын пэйж хуудаснуудад зар мэдээлэл байршуулах, Live буюу шууд




нэвтрүүлэг хийх, олон нийтийн үйлчилгээний төвүүдэд мэдээллийн цэг гаргах зэргээр мэдээллийг түгээн ажилласан.

2. Уг бүртгэлээр И-монголиа системд 10 залуучууд бүртгүүлснээс сонгон шалгаруулалтын ярилцлагыг 08 сарын 22-ны өдөр танхимаар зохион байгуулсан. Ярилцлагад нийт 3 залуу оролцон тэнцэж эрүүл мэндийн үзлэгт орсноос 2 залуу 08 сарын 24-нээс эхлэн вакумжуулсан сургалтад хамрагдаж эхлээд байна.



Хандалт: баннер-7095 Үзэлт: 1900 хүн



3. 2022 оны 08 сарын 01-07 өдөр иргэний гомдлын дагуу “ Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн барилгын ажил гүйцэтгэж буй JMC, EIL болон туслан гүйцэтгэгч 13 ААНБ-н ажлын талбайд АЗДТГ-аас томилсон ажлын хэсэгт хэлтсийн мэргэжилтэн орж ажилласан бөгөөд Хөдөлмөрийн гэрээ, цагийн бүртгэл, амралт

цайны цагийн зохицуулалт, ажлын орчин нөхцлийн талаар шалгалт хийн дүгнэх хуудсыг гарган ажлын хэсгийн даргад өгсөн.



4. 2022 оны 8 сарын 12-ны өдөр “Өөрийн санаагаа бизнес болгосон эмэгтэйчүүдийн уулзалт”-ыг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, 2022 онд хэрэгжиж буй Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг танилцуулж, мэдээлэл өгч ажилласан. Эмэгтэйчүүдийн 30 гаруй төлөөлөл оролцлоо. Орон нутгийн DTV-ээр олон нийтэд мэдээллийг түгээсэн. Хандалт: 4500 хүн



5. ХХҮЕГ-т Засгийн газраас зохион байгуулж буй “Оролцоо-2022” төслийн 1-р ээлжийн оролцогчдын байнгын ажлын байранд зуучлагдсан эсэх мэдээ, 2021, 2022 онд төслийн ярилцлагад орж тэнцсэн боловч төсөлд хамрагдаагүй иргэдийн мэдээг гарган хүргүүлээ.

6. “Залуучуудын хөгжлийн үндэсний цахим чуулган-2022”-д ХХҮГ-аас оролцох 30 залуучуудын бүртгэлийг ХХҮЕГ-т явуулж, 08 сарын 25-ны өдөр тус залуучуудыг оролцуулсан.

## 2. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

## НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

✓ 2022 оны 08 дугаар сарын 15, 25-ны өдөр нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, 08 дугаар сарын 20-нд цалинтай ээж, жирэмсэн эхийн тэтгэмжийг давхардсан тоогоор 6441 иргэнд 756,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

✓ Иргэдийг банкны очер дараалалд зогсоохгүйн тулд утсаар холбогдож банкинд харилцах данс нээлгэж картаараа авч байх талаар зөвлөмж өгч ажилласан.

✓ Аймгийн Нэгдсэн эмнэлэг Гэмтэл согог судлалын үндэсний төвтэй хамтран ахмад настанд өндөр өртөгтэй мэс засал хийж эхэлсэн ба Аймгийн Эрүүл мэндийн даатгалын тасаг санхүүжилт байхгүй учир ахмадуудад хөнгөлөлт олгох боломжгүй болсон байна. Ингэснээр нийгмийн халамжийн санд өглөгтэй гарах эрсдэл үүсэн учир ХХҮЕГ-т санхүүжилт хүссэн албан бичиг үргүүллээ.

## ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН СУДАЛГАА, ӨРГӨДӨЛ

✓ Аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны 23 өргөдөл хүлээн авсан.

✓ Шинэ төрсөн хүүхдийг хүүхдийн мөнгөнд хамруулах талаар эцэг эхийн 143 өргөдлийг хүлээн авч програмд бүртгэн мэдээлэл өглөө.

✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 2022 оны 8 сард 1 удаа товлон хуралдуулж 29 хүүхдийн асуудлыг хэлэлцлээ. Уг хурлыг байнгын асаргаа болон хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлуулах хүүхдүүдийн өвчний картыг хүлээн авч цахим хэлбэрээр зохион байгуулсан.

✓ Иргэдийн хөгжлийн нэгдсэн төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Эрүүлжин хөгжих төв” ашиглалтанд орох гэж буйтай холбогдуулан хамрагдах хүүхэд болон тэдний эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргалаа.

Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох зорилтыг дэвшүүлсэн.

Энэхүү зорилтын хүрээнд Нийгмийн халамжийн нэгдсэн систем болох ehalamj.mn системийг 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн нэвтрүүлж эхэллээ. Ингэснээр иргэд халамжийн үйлчилгээнд цахимаар бүртгүүлэх боломжтой боллоо. Програмтай холбоотой сургалтыг ХХҮЕГ-аас цахимаар зохион байгуулж иргэдийн өргөдлийг хүлээн авч эхлээд байна.

## ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 08 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

### Нэг. Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ:

Хүүхдийн зуслангуудын үйл ажиллагааг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 22-ний өдөр хүртэлх хугацаанд 1, 2, 3 дугаар ээлжийн 9-18 насны 274 амрагч хүүхдүүдийг хүлээн авч ажилласан. Амрагч хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөгжлийн хөтөлбөрийг хүүхэд бүрийн оролцоонд тулгуурлан, нас, бие, сэтгэхүйн онцлог, сонирхол хэрэгцээнд нийцүүлэн, урьдчилан

бэлтгэл ажлыг хангаж зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж шаардлагатай материалын хүрэлцээг байнга хангаж ажилласан.

Зуслангийн менежерийн баталсан сүлжээ төлөвлөгөөнд үндэслэн бүлгийн багш нар 7 хоногийн ээлжийн төлөвлөгөөг боловсруулж албажуулан хөтөлбөрийн дагуу өглөөний 09:00 цагаас оройн 22:30 цаг хүртэл амрагч хүүхдүүд зусласгийн хөтөлбөрт үйл ажиллагаанд хамрагдсан. Мөн зусланд амрагч хүүхдүүдийн эрхийн бичгийн үнэ энэ жилийн хувьд 7 хоног амрахад 140,000 төгрөгөөр тогтоосон. Зуслангийн үйл ажиллагааны хүрээнд 3 ээлжийн 274 амрагч хүүхдийг хүлээн авч 38,160,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Аймгийн хүүхдийн зусланг эрхлэн явуулахад дэмжлэг үзүүлж аймгийн Засаг даргын 2022 оны “Санхүүжилт олгох тухай” А/419 дүгээр захирамжийг үндэслэн 29,631,749 төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсан. Үүнд: Зуслангийн аж ахуйн материал, хүнсний материал, унааны зардал, зуслангийн эмнэлэгт шаардлагатай эд материал зэргийг авч зарцуулсан. Энэ зуны ээлж дууссан тул зуслангийн эд хөрөнгийг битүүмжилж, няравт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж байна.

#### **Залуучуудын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ:**

08 дугаар сарын 25-ны өдрийг “Монголын залуучуудын өдөр” болгон тэмдэглэж ирсэнтэй холбогдуулан тус өдрийг угтаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Залуучуудад чиглэсэн 13 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулж ажилласан. Залуучуудын хандлага, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүмүүжлийн чанартай арга хэмжээ” “Харилцаанд нөлөөлөх хүчин зүйлс”, “Иргэдийн оролцоо, иргэний төсөв” 5 удаагийн сургалтад 130 хүн хамрагдсан. Залуучуудын оролцоог нэмэгдүүлэхээр “Залууст ээлтэй Засаг даргын шийдвэр” “Үндэсний цахим чуулган” “Өөрийн санаагаа бизнес болгосон бүсгүйчүүдийн туршлага солилцох уулзалт” NEXTGEN төсөл, хөдөлмөр эрхлэлтийн Старт-ап, Оролцоо төслүүдийн мэдээллийг танилцуулах уулзалтыг тус тус зохион байгуулж 270,400 төгрөгийг зарцуулсан.

#### **Гурав. Хариу үйлчилгээний чиглэлээр:**

Түр хамгаалах байраар үл хайхрах хүчирхийллийн хохирогч бага насны 3 хүүхдийг хүлээн авч, аюулгүй хамгааллын үйлчилгээг 2 хоногийн хугацаатай үзүүлэн ажилласан. Хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж хүлээлгэн өгсөн.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд тайлант сард Замын-Үүд, Айраг, Сайншанд, Алтанширээ сумдаас 7 дуудлага мэдээлэл ирүүлсэн. Дуудлага мэдээллийн хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл бие махбодын хүчирхийлэлд өртсөн 3, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 1, үл хайхрах хүчирхийллийн хохирогч болсон 1, үе тэнгийн хүчирхийлэлд өртсөн 2 хүүхэд байна.

Дуудлага мэдээллийг эцэг эх асран хамгаалагчийн зүгээс ирүүлсэн 6, хүүхэд өөрөө хандсан 1 кейс тус тус байна. Харьяа хамтарсан багт кейсийг шилжүүлж хяналт тавьж ажиллаж байна.

### **ТАВ. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС**

*Санхүү, төрийн сангийн чиглэлээр:*

***Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:***

- 2022 оны 08-р сард орон нутгийн төсөвт 42,3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 27,8 тэрбум төгрөгийн орлого төвлөрч 65%-ийн биелэлттэй байна.
- Шилэн дансны хуулийн дагуу [shillendans.gov.mn](http://shillendans.gov.mn) сайтад сар бүр 8-ны дотор мэдээллээ хугацаанд нь бүрэн оруулсан. Нийт төсөв хөрөнгөтэй холбоотой 30 захирамж байрлуулсан.
- Сайншанд, Замын-Үүд, Даланжаргалан, Өргөн, Хатанбулаг сумдаас нийт 2,5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн.
- Сумдад 42,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.
- Орон нутгийн байгууллагад 494,5 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтад 2,7 тэрбум, төрийн өмчит сургууль, цэцэрлэг, соёл, эрүүл мэндийн төвүүдэд тогтмол зардалд нийт 260,7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Нэмэлт санхүүжилтийн 25 байгууллагын хүсэлтийг үндэслэн 109,5 сая төгрөгийн хүсэлтийг үндэслэн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээсэн.
- И-Баланс програмд шинээр үүссэн 2 аж ахуйн нэгж байгууллагыг бүртгэсэн.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 2022 оны 08 сарын 1-31-ны хооронд нийт 1106 гүйлгээний 11.8 тэрбум төгрөгийн төлбөр тооцоог Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд бүртгэснийг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн шаардлагатай тохиолдолд анхан шатны баримтын бүрдлийг тулган баталгаажуулж ажилласан.

#### **4.1 Статистикийн хэлтэс:**

##### **Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Долоо хоног бүрийн даваа гаригт судалдаг гол нэр төрлийн 32 бараа, бүтээгдэхүүний үнийг Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, мэдээний PPI програмд шивэн, хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд дамжуулав. Мөн 14 сумаас гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг судалж танилцуулга бэлтгэн 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар тогтмол тархааж байна.
- Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2022 оны 08 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, 600 гаруй хэрэглэгчдэд цахим болон хэвлэмэлээр тархааж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулсан.
- Сар бүрийн аж үйлдвэр /АҮ-1, зоогийн газрын үйл ажиллагааны сарын тайлан /А-ЗГ-1/, зочид буудлын газрын үйл ажиллагааны сарын тайлан /А-ЗБ-1/, хөдөө аж ахуйн /ХАА-7,ХАА-8,ХАА-10/ мэдээ тайланг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч нэгтгэн нягтлан шалгаж программд шивж ҮСХ-д хугацаанд нь дамжуулсан.
- Өрхийн нийгэм, эдийн засаг, Ажиллах хүчний 8-р сарын судалгаанд судлаач А.Дамчой, Б.Мөнх-Эрдэнэ, Г.Болдмаа нар ажиллав. ӨНЭЗС, АХС-нд Замын-Үүд, Айраг, Иххэт, Даланжаргалан, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ,

Сайншанд сумдын 120 өрх хамрагдаж, мэдээлийг бүрэн цуглуулж, боловсруулан ҮСХ-нд дамжуулсан.

#### **4.2 Татварын хэлтэс:**

##### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:**

- Улс ба орон нутгийн төсөвт 2468.9 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Татварын орлогын төлөвлөгөө биелүүлэх, урьд оны өрийг барагдуулах ажлын хүрээнд ТЭХ-ийн дагуу өртэй 9 татвар төлөгчид албадан өр барагдуулах ажиллагаа эхлүүлж өр барагдуулах тухай нэхэмжлэл гардуулж ажилласан. Үүний үр дүнд урьд оны өрөөс 20,2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 8 төрлийн нийт 2254 татварын тайлан, 275 хүсэлтийг хүлээн авч ажилласан. Тайлант сард 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 198, өрөөгөөр 235 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийж үйлчилгээ үзүүлсэн.
- Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 11 хуулийн этгээдийн мэдээллийг баазад бүртгэж ажиллалаа. НӨАТ суутган төлөгчөөр 7 хуулийн этгээдийг бүртгүүлсэн.
- Дуудлагаар татварын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ орон нутагт хэрэгжиж 18001288 дугаарын утсаар 1100 татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлсэн.
- Татвар төлөгчдөөс 1800-1288-д 105 гомдол хуваарилж, 58 гомдлыг шийдвэрлэв.
- Замын-Үүд сумын татварын тасаг И баримт болон ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар 3 байгууллагын 85 татвар төлөгчид сургалт зохион байгуулсан. Тариалан эрхлэгч 62 татвар төлөгчдөд мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тус аймагт зохион байгуулж буй тариалангийн бүртгэлийн цахим системийн сургалтад оролцогч нарт татварын хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч, сургалт орсон.

#### **4.3 Орон нутгийн өмчийн газар :**

##### **Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц**

- Худалдан авах ажиллагаа: Нийт 9 ажлын тендерийг зохион байгуулж, 8 ажлын гэрээ байгуулж, эрх олгогдсон. Техникийн тодорхойлолтоор 5 ажлын тоо хэмжээ хүлээгдэж байна.
- Өмч: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай

хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг 2022 онд явуулахаар шийдвэрлэгдсэний дагуу тооллогын нэгтгэлийг хийж гүйцэтгэж байна. Нэгтгэл 95 хувийн гүйцэтгэлэй байна. Дорноговь аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 07/04 дугаар тогтоолоор Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Фургон маркийн авто машин, Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Киа РИО маркийн 2 авто

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжилт
---	---------------------------	-----------

машин, Верна аксент маркийн авто машин, Ниссан Патрол маркийн авто машин, Сайншанд сумын Захирагчийн ажлын албаны Коралла фиэлдэр нийт 6 авто машиныг худалдан борлуулахаар шийдвэрлэгдсэний дагуу 2 автомашины дуудлага худалдааг 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Үлдсэн 3 автомашинд оролцогч байхгүй дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй.

#### 4.4 Санхүүгийн хяналт, аудитын алба:

##### Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Аймгийн Засаг даргын баталсан 2022 оны төлөвлөгөө, албаны даргын баталсан 01 удирдамжийн дагуу Сайншанд сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020, 2021 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.
- Аймгийн Засаг даргын Орлогчийн 2022 оны 08 сарын 02-ны өдрийн 02/1010 тоот албан бичиг, албаны даргын 2022 оны 08 сарын 03-ны өдрийн баталсан 08 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021, 2022 онуудын үйл ажиллагаанд санхүүгийн сэдэвчилсэн хяналт шалгалтыг 2022 оны 08 сарын 03-ны өдрөөс эхлүүлж, шалгалтаар СХШУАБ-ийн 3 акт тогтоож, шалгалтын тэмдэглэлийг Аймгийн Засаг даргад 2022.08.24-ний өдрийн 146 тоот албан бичгээр, хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмжийг Сайншанд сумын Засаг даргад 2022.08.24-ний өдрийн 147 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Даланжаргалан сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тэмдэглэл, холбогдох материалыг хуулбарлан Авлигатай тэмцэх газарт 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 143 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Энэ сард актын төлбөрийн үлдэгдлээс 9964,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

#### **ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

<b>Нэг. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр</b>		
1	Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтлөх, удирдлагуудад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих	-Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар 3 -Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3 -Засгийн газрын тогтоол 4 -Аймгийн ИТХ-ын тогтоол 2 зэрэг нийт 12 хууль тогтоомжийг хяналтад авч, бүртгэл хөтлөн удирдлагуудад танилцуулсан.
<b>Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр</b>		
2	Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнах	Хяналт-шинжилгээ үнэлгээний системийн “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт” цонхонд Монгол Улсын Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгавар гэсэн 63 заалт оруулснаас 42 арга хэмжээг хэлтээс тайлагнаж, 21 арга хэмжээг холбогдох хэлтсүүдэд хуваарилж ХШҮ-ний системд хугацаанд нь баталгаажуулсан.
3	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/280 дугаар захирамжийг шинэчлэх	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 280-р захирамжийг шинэчлэн найруулах төсөл боловсруулсан.
<b>Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын чиглэлээр:</b>		
4	www.dornogovi.unelgee.gov.mn цахим санд төрийн бодлогын баримт бичгийн хуваарилалтыг хийж, шинээр томилогдсон албан хаагчдад хяналт-шинжилгээ үнэлгээний цахим санд ажиллах эрх нээлгэж холбогдох хэлтэс, агентлаг, албан хаагчдад мэдээлэл өгч, арга зүйгээр хангах	ХШҮ-ний цахим санд Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгавар гэсэн 63 арга хэмжээнээс 21 арга хэмжээг холбогдох хэлтсүүдэд хуваарилалт хийсэн. 8 сард ХШҮ-ний системд шинээр албан хаагч бүртгээгүй.
<b>Гурав. Төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр</b>		
5	Хэлстийн сарын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжүүлэн ажиллах	Хэлтсийн 8 дугаар сарын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажилласан.
6	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг хийж гүйцэтгэх	МАН-ын дэргэдэх эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагаас ирсэн имэйл-ийн дагуу “Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” хөтөлбөрийн 2018-2021 оны жилийн эцсийн тайланг цахимаар илгээсэн. Монгол Улсын Засгийн газраас Дорноговь аймгийн бодлогын баримт бичгийн 2021 оны үйл ажиллагааны тайланд ХШҮ хийж, дүгнэлт, зөвлөмж ирүүлсэнийг хяналтад авч, хэлтсүүдэд танилцуулсан.
7	Хэлтэст ирсэн албан бичгийг хуульд заасан хугацаанд	8 дугаар сарын байдлаар хэлтэст албан бичиг ирээгүй.



	ШИЙДВЭРЛЭХ	
--	------------	--